

11

**ГРУПП КОМПАНИУДЫН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН
ТАЙЛАГНАЛ БА ШИНЖИЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙН АСУУДАЛ**

Д.Нямаа

Манай улсын хэмжээнд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн албанд бүртгэгдсэн 60 мянга орчим аж ахуйн нэгжээс үйл ажиллагаа явуулж санхүүгийн тайлангаа бэлтгэж толилуулдаг 42,2 мянган аж ахуйн нэгж байдаг. Үүнээс 35,7 мянга орчим аж ахуйн нэгж нь компанийн засаглалтай бөгөөд тэдгээрийн дотор толгой болон охин компаниудыг багтаасан 320 орчим групп компаниуд байна.

“Санхүүгийн нэгтгэсэн ба тусдаа тайлан” хэмээх НББОУС-27-д зааснаар: **Санхүүгийн нэгтгэсэн тайлан** гэдэг нь толгой компани болон түүний бүх охин компаниудыг багтаасан бүлэг аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланг нэг аж ахуйн нэгжийнх шигээр толилуулсан санхүүгийн тайлан бөгөөд **толгой компани** гэдэг нь нэг эсвэл хэд хэдэн охин компани бүхий аж ахуйн нэгж, **охин компани** гэдэг нь өөр аж ахуйн нэгж (толгой компани)-ийн хяналтанд байгаа аж ахуйн нэгж юм.


Хяналт гэж үйл ажиллагаанаас нь өгөөж хүртэхийн тулд аж ахуйн нэгжийн санхүүгийн болон үндсэн үйл ажиллагааны бодлогыг нь удирдан зохицуулах эрхийг хэлдэг.

Толгой болон охин компаниудыг багтаасан бизнесийн нэгдэл буюу групп компаниудыг босоо /horizontal/ чиглэлийн буюу 1 салбар дахь компаниудын нэгдэл, хэвтээ /vertical/ чиглэлийн буюу тухайн аж ахуйн нэгж худалдан авагч эсвэл бэлтгэн нийлүүлэгчтэйгээ нэгдсэн компаниудын нэгдэл, конгломерат /conglomerate/ чиглэлийн буюу салбар эсвэл зах зээлтэйгээ холбоогүй компаниудын нэгдэл гэж ангилж болно.

Дээрх ангиллын дагуу авч үзвэл, манай улсын Групп компаниудын үүсэн байгуулагдсан зохион байгуулалтын хэлбэр эхэн үедээ буюу 1993 оноос 2000 он хүртэлх хугацаанд босоо чиглэлтэй, 2001 оноос хойшхи хугацаанд нэгдэж, нийлсэн компаниуд нь хэвтээ болон конгломерат чиглэлтэй болжээ.

Түүнчлэн, групп компаниудыг хувь оролцооны эзэмшилт буюу өмчлөлийн загвараар нь ангилж авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:


1.Толгой компани нь охин компанийг шууд хяналтандаа авсан бизнесийн нэгдэл
/Direct subsidiary control/



2.Толгой компани нь охин компанийг шууд бусаар хяналтандаа авсан бизнесийн нэгдэл:


/Indirect subsidiary control/

А. Эцэг-хүү-ач хүүгийн харилцан хамааралд байгаа бизнесийн нэгдэл
/father-son-grandson relationship/




Б.Холбоотой компаниудыг үүсгэсэн бизнесийн нэгдэл */Connecting affiliation/*

(Бизнесийн нэгдэл дэх толгой болон охин компаниуд аль аль нь ижил компанид хөрөнгө оруулсан хэлбэр)



В.Бизнесийн нэгдлийн бүрэлдэхүүн дэх компаниуд өмчийн хувь оролцоогоо харилцан эзэмшсэн бизнесийн нэгдэл
Mutual ownership /




Дээрх групп компаниуд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай болон Компанийн тухай Монгол улсын хуулиуд, түүнчлэн Нягтлан Бодох Бүртгэлийн Олон улсын Стандартын Зөвлөл /НББОУСЗ/-өөс баталж гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт /СТОУС /-ын шаардлагын дагуу Санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэж толилуулах үүрэгтэй бөгөөд Санхүүгийн нэгтгэсэн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна: Үүнд:

- (а) **Тайлант үеийн эцсээрх санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан буюу нэгтгэсэн баланс / Consolidated statement of financial position or Consolidated Balance Sheet/ ;**
- (б) **Тайлант үеийн орлогын /ашиг, алдагдлын/ нэгтгэсэн тайлан /Consolidated Income Statement / ;**
- (в) **Тайлант үеийн өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан /Consolidated Statement of changes in Owner's equity/;**
- (г) **Тайлант үеийн мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан /Consolidated Cash flow statement/;**
- (д) **Нягтлан бодох бүртгэлийн тодорхой бодлогууд болон бусад тодруулсан мэдээлэл бүхий тайлбар / Disclosure, including accounting policy and notes/ зэрэг болно.**

Групп компаниуд нь Санхүүгийн нэгтгэсэн тайлангаа дээрх бүрэлдэхүүнтэйгээр бэлтгэж толилуулахаас гадна улирал, хагас жил, жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд болон толгой, охин компани тус бүрийн санхүүгийн тусдаа тайланд шинжилгээ хийж хүрсэн үр дүнгээ харах, цаашдын бодлого чиглэлээ тогтоож байх нь зайлшгүй чухал бөгөөд санхүүгийн нэгтгэсэн тайлангийн шинжилгээ нь групп компаниудын

бизнесийн үйл ажиллагааны явц үр дүн, гүйцэтгэлийг тогтсон үзүүлэлтийн системээр хэмжиж тооцоолж үнэлгээ дүгнэлт өгөхөд зориулагдана.

Санхүүгийн нэгтгэсэн тайлагнал дахь групп компаниудын мэдээллийн урсгал :



Санхүүгийн нэгтгэсэн тайлан нь толгой ба охин компаниудыг багтаасан бүлэг аж ахуйн нэгжийн санхүүгийн байдал болон үйл ажиллагааны үр дүнг нэг аж ахуйн нэгжийнх шигээр толилуулсан санхүүгийн тайлан учраас санхүүгийн тусдаа тайлангийн шинжилгээний арга аргачлалууд түүнд хийх шинжилгээнд түгээмэл ашиглагддаг.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд шинжилгээ хийж дүгнэлт өгөх асуудлаар Оросын , мөн барууны олон эрдэмтэд судалгаа хийж арга зүй боловсруулсан байдаг ба Оросын эрдэмтэн, судлаач Петухов Георгий Николаевичийн тодорхойлсон “Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн шинжилгээний арга зүй”, Якубовская Лилия Валерьевнагийн тодорхойлсон “Санхүүгийн нэгтгэсэн тайланг шинжлэх үзүүлэлтүүдийн харьцаа” болон бусад арга аргачлалд үндэслэн Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийх шинжилгээний ерөнхий арга зүйг харуулбал дараах байдалтай болно. Үүнд:

1. Нэгтгэсэн балансын шинжилгээ

Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан буюу нэгтгэсэн балансад хийх шинжилгээг дараах үе шатуудад хувааж авч үзнэ.

Нэгдүгээр үе шат. Групп компанийн нэгтгэсэн балансаарх хөрөнгө, эх үүсвэрийн хэлбэлзэл өөрчлөлт (хэвтээ шинжилгээ) болон бүтэц бүрэлдэхүүн (босоо шинжилгээ)-ийг өмнөх тайлангийн үетэй нь

зэрэгцүүлэн тодорхойлж дүгнэлт өгнө.

Хүснэгт

Нэгтгэсэн балансаарх дүн	Балансын үлдэгдэл (сая.төгрөгөөр)		Хувийн жин		2009-2010 оны өөрчлөлт	
	2010.12.31	2009.12.31	2010 он	2009 он	Сая төгрөг	Хувиар
1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ						
1.1. Мөнгөн хөрөнгө	8,198.2	6,457.0	4.34%	4.95%	1,741.2	27%
1.2. Авлага ба бусад тооцоо	70,910.5	34,237.8	37.51%	26.23%	36,672.7	107%
1.3. Бараа материалын нөөц	22,644.2	14,777.7	11.98%	11.32%	7,866.5	53%
1.4. Урьдчилж гарсан зардал, төлбөр	6,684.2		3.54%		6,684.2	
Эргэлтийн хөрөнгийн дүн	108,437.1	55,472.5	57.36%	42.50%	52,964.6	95%
2. ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ						
2.1. Үндсэн хөрөнгө	60,839.6	64,874.7	32.18%	49.70%	(4,035.1)	-6%
2.2. Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө	6,104.6	5,812.3	3.23%	4.45%	292.3	5%
2.3. Бусад биет бус хөрөнгүүд	13,666.5	4,371.3	7.23%	3.35%	9,295.2	213%
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	80,610.7	75,058.3	42.64%	57.50%	5,552.4	7%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	189,047.8	130,530.8	100.00%	100.00%	58,517.0	45%
3. ӨР ТӨЛБӨР						
3.1. Дансаарх өглөг	53,549.3	32,020.8	28.33%	24.53%	21,528.5	67%
3.2. Банкны зээл	24,555.8	17,187.0	12.99%	13.17%	7,368.8	43%
3.3. Бусад өглөгүүд	3,496.6	684.4	1.85%	0.52%	2,812.2	411%
3.4. Татварын өглөг	144.8	1,141.4	0.08%	0.87%	(996.6)	-87%
БХ өр төлбөрийн дүн	81,746.5	51,033.6	43.24%	39.10%	30,712.9	60%
3.6. Урт хугацаат өр төлбөр	77,770.6	43,212.2	41.14%	33.10%	34,558.4	80%
ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	159,517.1	94,245.8	84.38%	72.20%	65,271.3	69%
4. ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ						
4.1. Хувьцаат капитал	2,014.0	2,024.0	1.07%	1.55%	(10.0)	-0.5%
4.2. Дахин үнэлгээний нөөц	26,053.0	26,143.2	13.78%	20.03%	(90.2)	-0.3%
4.3. Хуримтлагдсан ашиг (алдагдал)	1,571.4	8,222.2	0.83%	6.30%	(6,650.8)	-81%
4.4. Хяналтын бус хувь оролцоо	(107.7)	(104.4)	-0.06%	-0.08%	(3.3)	3%

ЭЛИЙН ЗАСАГ:

ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	29,530.7	36,285.0	15.62%	27.80%(6,754.3)	-19%
ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН	189,047.8	130,530.8	100.00%	100.00%	58,517.0 45%

Хоёрдугаар үе шат. Балансын хөрөнгийг хөрвөх чадвараар нь болон өр төлбөрийг барагдуулах боломжийнх нь хувьд бүлэглэж нэгтгэсэн балансын хөрвөх чадварыг тодорхойлох шаардлагатай.

Хөрвөх чадварын түвшин буюу хөрөнгийн мөнгөнд хувирах хугацаанаас хамааруулан хөрөнгийг дараах бүлэгт хувааж үздэг.

A1.Төлбөрт бэлэн байгаа хөрөнгө=Мөнгөн хөрөнгө+БХХО

A2.Түргэн хөрвөх хөрөнгө=Богино хугацаат дансаарх авлага

A3.Удаан хөрвөх хөрөнгө=Бараа материал + Урт хугацаат дансаарх авлага + Бусад эргэлтийн хөрөнгө

A4.Хэцүү хөрвөх хөрөнгө =Эргэлтийн бус хөрөнгө

Хөрөнгийн эх үүсвэрийг төлбөр төлөх хугацаанаас нь хамааруулан дараах байдлаар ангилна.

П1.Түргэн төлөгдөх өр төлбөр =Дансаарх өглөг

П2.Богино хугацаат пассив=Богино хугацаат зээл + Ноогдол ашгийн өглөг +Бусад богино хугацаат өр төлбөр

П3.Урт хугацаатай пассив =Урт хугацаатай өр төлбөрүүд + Урьдчилж орсон орлого + Төлбөрт зориулсан нөөцүүд

П4.Байнгын капитал=Өмч болон нөөцүүд (компанийн өөрийн капитал).

A1≥П1, A2≥П2, A3≥П3, A4≤П4 гэсэн хамаарал биелэгдэж байвал хөрөнгө хөрвөх чадвартай гэж тооцогдоно.

/Хүснэгт 2 /

№	Тооцсон журам	Шалгуур	Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар		“ААА Групп” ХХК (толгой компани)	
			2010 он	2009 он	2010 он	2009 он
A1	Төлбөрт бэлэн байгаа хөрөнгө=МХ+БХХО	A1≥П1	8,198.20	6,457.00	7,796.10	6,401.70
П1	Түргэн төлөгдөх өр төлбөр =Дансаарх өглөг		53,549.30	32,020.80	51,851.60	25,535.20
A2	Түргэн хөрвөх хөрөнгө=Богино хугацаат ДА	A2≥П2	70,910.50	34,237.80	144,789.40	66,289.20
П2	Богино хугацаат пассив=Богино хугацаат зээл + Ноогдол ашгийн өглөг +Бусад богино хугацаат өр төлбөр		28,197.20	19,012.80	29,025.40	23,226.30
A3	Удаан хөрвөх хөрөнгө=Бараа материал + Урт хугацаат дансаарх авлага + Бусад эргэлтийн хөрөнгө	A3≥П3	29,328.40	14,777.70	5,115.10	5,109.10
П3	Урт хугацаатай пассив =Урт хугацаатай өр		77,770.60	43,212.20	77,770.70	43,208.40

		төлбөрүүд + Урьдчилж орсон орлого + Төлбөрт зориулсан нөөцүүд					
A4		Хэцүү хөрвөх хөрөнгө =Эргэлт. бус хөрөнгө	A4≤П4	80,610.70	75,058.30	30,585.50	50,559.30
П4		Байнгын капитал=Өмч болон нөөцүүд (компанийн өөрийн капитал).		29,530.70	36,285.00	29,638.40	36,389.40

Гуравдугаар үе шат. Нэгтгэсэн балансад төлбөрийн чадварын харьцаануудыг тооцоолох замаар төлбөрийн чадварын шинжилгээг хийнэ.

Төлбөрийн чадварыг үүссэн өр төлбөр, харилцагчийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагыг зохих хугацаанд нь төлж барагдуулахад бэлэн байгаа болон ойрын хугацаанд цугларах төлбөрийн хэрэгсэлүүдийн хүрэлцэхүйц байдлаар тодорхойлно.

Үүссэн өр төлбөрийг хэдийд төлж барагдуулах хугацаанаас нь хамааруулан төлбөрийн чадварыг өнөөгийн, ойрын, хэтийн боломж гэж ангилан хэмждэг.

Дөрөвдүгээр үе шат. Компанийн хараат бус байдлын түвшинг тодорхойлох санхүүгийн тогтворжилтын шинжилгээг хийнэ.

Өөрийн болон гаднаас татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн зохистой хувь оролцоо, санхүүгийн хараат бус /бие даасан/ байдлыг хангах замаар бизнесийн үйл ажиллагаа, орлого үр дүнгийн өсөлтийг хангах боломжийг санхүүгийн тогтвортой байдал гэдэг.

Тавдугаар үе шат. Үйл ажиллагааны идэвхижлийн шинжилгээ буюу хөрөнгийн ашиглалтын шинжилгээг хийнэ. Энэ зорилгоор дараах 2 бүлэг үзүүлэлтийг тооцож дүгнэлт өгөх нь зүйтэй.

1. Эргэцийн ерөнхий үзүүлэлтүүд
2. Хөрөнгийг удирдах үзүүлэлтүүд

Хөрөнгийн ашиглалтын шинжилгээнд үйлдвэрлэлийн циклийн үргэлжлэх хугацаа болон түүний бүтэц, уг циклийн үргэлжлэх хугацааны өөрчлөлтийн үндсэн шалтгааныг тодруулж дүгнэх зайлшгүй шаардлагатай. Хөрөнгийн ашиглалтыг оруулсан хөрөнгийн нэгж тутмаас олж буй нийт орлого болон бүтээмжийн өсөлт, хөрөнгийн эргэцээр хэмждэг. Эдгээр үзүүлэлтийг орлогын дүн /борлуулалтын болон нийт орлого/-г оруулсан хөрөнгийн дундаж үлдэгдэлд харьцуулан тооцно. Хөрөнгийн дундаж үлдэгдлийг нийтлэг жишгийн дагуу хронологийн дунджаар, наад зах нь тайлант үеийн эхний ба эцсийн үлдэгдлийн дунджаар авах нь зөв болно.

/ Хүснэгт 3/

№	Үзүүлэлтүүд	Тооцсон журам	Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар		"AAA Групп" ХХК (толгой компани)	
			2010 он	2009 он	2010 он	2009 он
1. Санхүүгийн тогтворжилт						
	Өөрийн капиталын оролцоо, хувь	ӨК:НХ	15,62	27.80	15.74	28.35
1.1.	Нийт өрийн харьцаа	ГК:ӨК	5.4017	2.5974	5.3528	2.5274
1.2.	Ажлын капитал	ЭХ-БХӨ	26,690.60	4,438.80	76,823.60	29,038.42
1.3.	Санхүүгийн уян хатан байдал	АК:ӨК	0.9038	0.1223	2.5920	0.7980
1.4.	Эргэлтийн хөрөнгийн харьцаа	ЭХ:БХӨ	1.3265	1.0870	1.9499	1.5955
1.5.						
2. Төлбөрийн чадвар						
2.1.	Төлбөрийн өнөөгийн боломж	Мх:БХӨ	0.1003	0.1212	0.0964	0.1313
2.2.	Төлбөрийн ойрын боломж	(Мх+Ав):БХӨ	0.9677	0.7921	1.8866	1.4907
2.3.	Эргэлтийн хөрөнгийн санхүүжилт	АК:ЭХ	0.2461	0.0800	0.4871	0.3732
2.4.	Өр төлбөр ба авлагын харьцаа	БХӨ:Авлага	1.1528	1.4906	0.5586	0.7356
3. Хөрөнгийн ашиглалт						
3.1.	Нийт хөрөнгийн ачаалал	НО:НХ	0.9765	1.6416	0.3422	0.7879
3.2.	Өөрийн хөрөнгийн ачаалал	БО:ӨК	6.2173	5.7977	2.1731	2.5985
3.3.	Авлага цугларуулалтын хугацаа	Ав:БО*360	139.00	58.59	809.27	252.37
3.4.	БМН-ийн эргэцийн хугацаа	Н:ББӨ*360	48.70	28.31	0.25	20.97
3.5.	Үйл ажиллагааны цикл	(3.3.+3.4.)	187.70	86.90	809.52	273.34
3.6.	БХӨ-ийн барагдуулалт (хугацаа)	Өгл:МЗ*360				
3.7.	Мөнгөн циклийн хугацаа	(3.5.-3.6.)				
4. Хөрөнгийн өгөөж, хувиар						
4.1.	Борлуулалтын ашигт ажиллагаа	ҮАЦА:БО	(0.0372)	0.0139	(0.0618)	(0.0078)
4.2.	Нийт хөрөнгийн өгөөж	ХТӨЦА:НХ	(0.03)	0.05	(0.0350)	0.0438
4.3.	Өөрийн хөрөнгийн өгөөж	ТӨЦА:ӨК	(0.22)	0.1699	(0.2223)	0.1545
4.4.	Зардлын түвшин	НЗ:НО	1.035	0.9741	1.1023	0.9450

2. Орлогын нэгтгэсэн тайлангийн шинжилгээ

Орлогын нэгтгэсэн тайлангаас группын хэмжээгээрх нийт болон үндсэн ажиллагааны орлого, зардлын өсөлт бууралт, бүтэц бүрэлдэхүүнийг тодорхойлж орлогын анхдагч хуваарилалт, орлогын нэгжид ногдох зардал, ашгийн түвшингийн талаар дүгнэлт өгнө.

/Хүснэгт 4/

Орлогын нэгтгэсэн тайлангаарх дүн	Тайлант оны гүйцэтгэл (сая.төгрөгөөр)		Хувийн жин		2009-2010 оны өөрчлөлт	
	2010 он	2009 он	2010 он	2009 он	Сая төгрөг	Хувиар
Цэвэр борлуулалт	183,602.4	210,368.3	100.00%	100.00%	(26,765.9)	(0.13)
2. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	167,295.0	187,897.8	91.12%	89.32%	(20,602.8)	(0.11)
3. Нийт ашиг	16,307.4	22,470.5	8.88%	10.68%	(6,163.1)	(0.27)
4. Үйл ажиллагааны зардал	23,143.2	19,538.6	12.61%	9.29%	3,604.6	0.18
5. Үйл ажиллагааны ашиг	(6,835.8)	2,931.9	-3.72%	1.39%	(9,767.7)	(3.33)
6. Үйл ажиллагааны бус орлого	996.0	3,834.9	0.54%	1.82%	(2,838.9)	(0.74)
Үйл ажиллагааны бус зардал	722.5	603.1	0.39%	0.29%	119.4	0.20
7. Татварын өмнөх ашиг	(6,562.3)	6,163.7	-3.57%	2.93%	(12,726.0)	(2.06)
8. Орлогын татвар	28.4	681.6	0.02%	0.32%	(653.2)	(0.96)
9. Хяналтын эрхгүй хувь оролцогчдод ногдох ашиг (алдагдал)	-2.1	(78.3)	0.00%	-0.04%	76.2	(0.97)
10. Татварын дараах ашиг (алдагдал)	(6,588.6)	5,560.4	-3.59%	2.64%	(12,149.0)	(2.18)
11. Компанийн нийт орлого	184,600.5	214,281.5	100.00%	100.00%	(29,681.0)	(0.14)
Компанийн нийт зардал	191,189.1	208,721.1	103.57%	97.41%	(17,532.0)	(0.08)
Орлогын 1 төгрөгт ногдох зардал, төгрөгөөр	1.04	0.97	-	-	0.1	0.06

Дүгнэлт.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн шинжилгээний арга зүйн асуудлаарх дээрх эрдэмтдийн дэвшүүлсэн, санал болгосон үзүүлэлтүүдийг судалгаа хийсэн групп компанийн хэмжээгээр болон толгой, охин компани тус бүрээр тооцоолж үзэхэд санхүүгийн нэгтгэсэн тайлангаарх мэдээлэлд үндэслэн хийсэн тооцоолол илүү бодитой, шалгуур үзүүлэлтүүдийн утгатай илүү ойролцоо гарч байгаа юм.

Иймд, групп компаниудын бүрэлдэхүүн дэх толгой болон охин компани тус бүрийн санхүүгийн тусдаа тайлан болон тэдгээрт хийсэн шинжилгээ дүгнэлтээс группийн хэмжээгээрх санхүүгийн нэгтгэсэн тайлан болон түүнд хийсэн шинжилгээ, дүгнэлт нь санхүүгийн нэгтгэсэн тайлан хэрэглэгчдийн шийдвэр гаргалтанд хэрэглэгдэх тухайн бүлэг аж ахуйн нэгжийн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнгийн талаарх илүү бодитой, үнэн зөв мэдээллийг бий болгодог нь харагдлаа.

Ном зүй.

1. Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн хууль 2001 он
2. Мюллер Г.Гернон Х.Мийк Г.Учет: Международная перспектива.“Финансы и статистика” 2003 он
3. Ahmed Riahi Belkaoui “Multinational Accounting” Chapter 6 1994 он
4. Christopher Nobes, Robert Parker “Comparative International Accounting” 1995 он
5. E.John .Larsen “Modern advanced accounting” 2005 он
6. Stephen A.Ross, Randolph W.Westerfield, Jeffrey Jaffe “Corporate Finance” ,Chapter 29.
7. Mergers and Acquisitions 2006
8. International Accounting Standards Board /IASB/ “International Financial Reporting Standards ”– 2010 он
9. Joe B.Hoyle, Thomas F.Schaefer , Timothy S.Doupnik “Advanced accounting” ninth edition 2009 он
10. В.В.Ковалев , Вит.В.Ковалев “Финансовая отчетность, Анализ финансовой отчетности, Москва 2004 он
11. Петухов Георгий Николаевич. Автореферат диссертации “Методическое развитие консолидированной финансовой отчетности “ 2009 он
12. Якубовская Лилия Валерьевна. Автореферат диссертации “Особенности анализа консолидированной финансовой отчетности” 2007 он
13. “AAA” Групп” ХХК болон түүний охин компаниудын санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл 2009, 2010 он